

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-9

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан	5-8
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын товч тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/	8-9
3. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг жагсаалтад ороогүй хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	9

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
06 дугаар сарын 29-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Л.Оюун-Эрдэнэ;
Чөлөөтэй: Б.Батбаатар, Б.Баярбаатар, Л.Гантөмөр, Т.Доржханд,
Ч.Лодойсамбуу, Б.Чойжилсүрэн, Д.Энхтуяа;
Тасалсан: Д.Амарбаясгалан, Э.Болормаа, О.Цогтгэрэл.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч Н.Мягмар, Ц.Уртнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас, Б.Баясах нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

Нэр дэвшигчээс болон тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Б.Жавхлан: 1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд Нэргүйн Мягмарыг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	5
Бүгд:	18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд Цэцэгмаагийн Уртнасанг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	5
Бүгд:	18

72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас, Б.Баясах нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Жавхлан: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	6
Бүгд:	19

68.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг жагсаалтад ороогүй хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа нарын 65 гишүүн 2026.06.22-ны өдөр өргөн мэдүүлсэн Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	8
Бүгд:	20

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 29-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг эхлүүлье. Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дараах гишүүд одоогоор ирцэд ороод байна. Аюушийн Ариунзаяа гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Бадрахын Найдалаа гишүүн, Чинбатын Ундррам гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн. Эдгээр 17 гишүүн хуралд оролцож байна. Ирцийг та бүхэнд танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр ерөнхийдөө товчхон 3 асуудал байгаа.

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдэд нэр дэвшигчдийн сонсголын тайлангаа сонсчихно.

2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчдийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/. Энэ нөгөө Олон нийтийн радио, телевизийн зөвлөлийн гишүүд байгаа.

3. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал байна.

Ийм 3 асуудал байгаа. Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүд байна уу. Алга байна.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд нэр дэвшигчдийн сонсголын тайланг хэлэлцэж эхэлье.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчдийн сонсголын тайланг танилцуулна. Нэр дэвшигч Нэргүйн Мягмар, Цэцэгмаагийн Уртнасан нарын танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо 2-ыг, Монгол Улсын Ерөнхийлөгч 2-ыг, Улсын Дээд

шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хуралд нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсголыг хийхээр тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1.Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Цэцэгмаагийн Уртнасан, Нэргүй Мягмар нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2.2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай 6 дугаар тогтоолыг баталж, 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг томилсон.

3.Сонсголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст буюу Parliament.mn-д байршуулсан. Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудас бүхий зарыг Улсын Их Хурлын цахим хуудсанд 14 хоногийн хугацаанд байршуулсан болно. Сонсгол зохион байгуулах зар мэдээллийн дагуу Байнгын хороонд ажиглагч, оролцогчоор бүртгүүлэх хүсэлт ирүүлээгүй.

4.2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Жавхлан, Алтангэрэл, Бат-Эрдэнэ, Болормаа, Бямбацогт, Батжаргал, Баярмаа, Ганбаатар, Гантөмөр, Даваасүрэн, Доржханд, Зулпхар, Лодойсамбуу, Мөнхбаатар, Одбаяр, Пүрэвдорж, Туваан, Ундрэм, Чойжилсүрэн, Шижир, Энхбаяр, Энхтуяа нар буюу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, нэр дэвшигчдийн сонсголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайлан сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана гэж заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Цэцэгмаагийн Уртнасан, Нэргүйн Мягмар нарыг ажлын хэсгийн тайлан, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд

тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Монгол Улсын Их Хурал Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Нэр дэвшигчдийн сонсголын тайлан болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Нэрээ өгнө үү. Шижир гишүүнээр тасаллаа. Шижир гишүүний микрофоныг нээе.

Ө.Шижир: Өдрийн мэнд би буруу санаагүй бол Мягмар гэдэг хүн дээр чинь 2 удаа санал хураагаад, хоёулан дээр нь уначихсан шүү дээ. Эхлээд санал хураагаад унасан. Дараа нь горимын санал гаргаад, төхөөрөмж ажиллахгүй байна гэж хэлээд дахиад унасан. Тэгээд сүүлд нь ямар горимоор санал оруулж ирснийг би мэдэхгүй байна. Батжаргал дарга төхөөрөмждөө миний гар хүргэж амжаагүй гэдэг санал гаргаад байна лээ. Тийм горимын санал байдаггүй шүү дээ.

Тэгээд Сонгуулийн ерөнхий хороонд орж байгаа гишүүд нь шударга бус аргаар, сонгуулийн луйврын аргаар ингээд Сонгуулийн ерөнхий хороонд ороод ирэхээр тэгээд цаашдаа сонгуулийг шударга хийнэ гэдэг итгэл үнэмшил хэнд төрөх юм. Хэнд төрөх юм. Эхний санал хураалтаар уначихсан. Горимын санал гаргаад, хүчингүй болгох санал нь дахиад уначихсан. Тэр чинь бүгдээрээ бүртгэл дээрээ байгаа шүү дээ. Тэгээд би Их Хурлын Тамгын газар луу тэр хуралдааны тэмдэглэл протоколыг албан бичгээр өгөөч гээд албан бичиг өгчихсөн байгаа. Тэгээд тэрийг авмаар байна. Тэгээд яг ямар дэгээр 2 удаа санал хураасан хүнийг оруулж ирж байгаа юм бэ. Дэгийн тухай заалтын аль заалтаар. Ямар горимоор гаргасан юм. Надад энэ дээр хариулт өгөөч.

Дахиад хэлье. Сонгууль шударга явуулах гэж байгаа, төрийн болон бүх нийтийн сонгуулийг шударга явуулах гэж байгаа, явуулах гэж очиж байгаа байдал нь ийм сонгуулийн шударга бус байдлаар ингээд очих гэж байна шүү дээ. Ийм логик байж болдог юм уу. Ийм зарчим байдаг юм уу. Тэгээд яах юм. Сонгуулийг цаашдаа ингэж хийх юм уу. Ноёны бух гэдэг шиг унахаар нь дахин дахин оруулж ирээд байх юм. 2, 3 өдөр дараалж хуралдуулаад, яг ямар горимоор, яг хэний ямар саналаар, ямар хуулийн заалтаар 2 удаа санал хураасан хүнийг орж ирж байгааг би асууя.

Б.Жавхлан: Дэгийн хуулиар өмнөх хуралдаан хаалттай болсон. Мөн дахиж хаалттайгаар үргэлжлүүлсэн. Дэг зөрчигдөөгүй. Хаалттай хуралдааны талаар энд бүрэн мэдээллийг микрофон дээр ярих боломжгүй Шижир гишүүн ээ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.2 дахь хэсэгт гишүүд нууц санал хураалт явуулахаар заасан байдаг. Иймд Байнгын хороо дээр мөн нууц санал хураалтыг цахимаар явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд бэлэн болсон байна. Анхааралтай байгаарай.

1.Нэр дэвшигч Нэргүйн Мягмарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар уг санал дэмжигдлээ.

2.Нэр дэвшигч Цэцэгмаагийн Уртнасанг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 72,2 хувиар уг санал дэмжигдлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн би өөрөө уншчихъя даа.

13.50 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.2 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна гэж, мөн 21.5.2 дахь заалтад Үндэсний зөвлөлийн гишүүнд Улсын Их Хуралд 7 хүнийг нэр дэвшүүлэхээр тус тус заасан бөгөөд нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйлд тусгасан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 5 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонголыг 06 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулахаар тов тогтоосон боловч гишүүдийн ирц хүрээгүй тул зохион байгуулагдаагүй.

Иймд товыг шинэчлэн тогтоох тогтоолын төслийг боловсруулсан байгаа.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Дугарсүрэнгийн Гүн-Үйлс, Чулуунбаатарын Батцэнгэл, Жанчивдоржийн Билэгсайхан, Дагвадоржийн Наранцэцэг, Дашзэвэгийн Мягмарсүрэн, Сандагийн Од-Эрдэнэ, Манлайжавын Төрманлай, Батболдын Энэрэлт, Лунагийн Энхжин, Гүнчин-Ишийн Энхбаяр нартай хийх нэр дэвшигчийн сонголыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулахаар тогтсугай.

2.Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг сонгосугай гэсэн ийм 2 заалттай төсөл бэлэн болсон байна.

Та бүхэнд танилцуулж дууслаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Төсөл төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд анхааралтай байгаарай. Гишүүд төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. Ариунзаяа, Ганбаатар, Даваасүрэн, Найдалаа, Номтойбаяр, Одбаяр, Туваан, Шижир гишүүд. Анхааралтай байгаарай.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 68,4 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

13.54 цаг.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдэд чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд түр байж байгаарай. Ерөөсөө ганцхан санал байгаа.

Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа нарын 65 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад эхлээд бэлдээдэхье. Гишүүд анхааралтай байгаарай. Ариунзаяа гишүүн, Ганбаатар гишүүн, Даваасүрэн гишүүн, Зулпхар гишүүн, Найдалаа гишүүн, Номтойбаяр гишүүн, Хэрлэн гишүүн, Шижир гишүүнд төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. Санал хураалт. 20 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд талархлаа.

13.55 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ